

ХОЁР. ШАШИН СУДЛАЛ

<https://doi.org/10.5564/spej.v46i37.2562>

Хоёр ёсыг хосолсон “Улаан сувдан эрхи” хэмээх зохиолын үзэл санааны тухай

Some ideological issues of the “Two Customs” Buddhist commandment manuscript ‘Lugs zung gi bslab bya mu thi’ la’i ‘phreng ba zhes bya ba bzhugs so”

Дамбын Гантөмөр¹

Доктор (Sc.D)

Шинжлэх Ухааны Академийн

Философийн хүрээлэн

Ёс зүй, сэтгэл судлалын салбар

gantumur_d@mas.ac.mn

Gantemur Damba

Doctor (Sc.D)

Department of Ethics & Psychology,

Institute of Philosophy,

Mongolian Academy of Sciences

gantumur_d@mas.ac.mn

Хураангуй:

Энэхүү өгүүлэлд “Хоёр ёсыг хосолсон улаан сувдан эрхи” хэмээх нэрт суртгаал оршивой”, “Ёс хоёрын суртгаал сувдан эрхи ориуулсан болой” хэмээгдэх хоёр өөр нэртэй гар бичмэлийн тухай болон уг сургаалын талаарх гадаад, дотоод дах судлагдсан байдал ба үндсэн үзэл санааны тухай тодруулах болно. V Далай лам Агваанлуvsанжамц (Ngawang Lobsang Gyatso 1617-1682) бээр зохиосон «Улаан сувдан эрхи» хэмээх тус сургаалыг монголын мэргэд орчуулж олон нийтийн хүртээл болгож байжээ. Сургаалын үзэл санаа нь буддын номлолыг үндэслэн нийтийн ёс зүйн хэм хэмжээнд тохируулан айлдсан бөгөөд энэ нь өнөөгийн удирдлагын ёс зүйд хамаарах боломжтой.

Түлхүүр үгс: хоёр ёс, буддын ёс зүй, сургаалын үзэл санаа, зам мөр, шашин, төрийн ёс

Abstract:

This paper attempts to study a Buddhist commandment manuscript which have found by two different named by us. “Lugs zung gi bslab bya mu thi’ la’i ‘phreng ba zhes bya ba bzhugs so” is the famous Buddhist morality commandment writing by Fifth Dalai Lama Ngawang Lobsang Gyatso (1617-1682). It has translated and disseminated by several Mongolian writers & monks. The paper clarifies about this manuscript, its literature research and the main ideology. Here we argue, the “two customs” (moral doctrine for monastic and lay people) as a Buddhist state and religion ideology could be applicable to the modern management ethical concepts.

Keywords: two principles, Buddhist ethics, teaching idea, path, religion, statehood, Jewel Translucent sutra

I. Оршил

Төвөд, Монгол оронд дэлгэрсэн хос ёсны сургаал нь төв үзлийг үндэслэгч Нагаржунын хаанд зориулсан “Эрдэнийн эрхи”, “Хаанд илгээсэн захидал”,

¹ © Зохиогч. 2022. Сэтгүүлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээл нь зохиогчийн оюуны өмч байх бөгөөд (CC BY- <https://creativecommons.org/licenses/by/4.0/>) нөхцөлийн хүрээнд ашиглана уу.

түшмэлд зориулсан “Билгийн гол модон”, харц албатад зориулсан “Рашааны дусал” зэрэг нь зохиолын үзэл санаанд тулгуурласан байдаг.

Эрдэмтэн Л.Хүрэлбаатар 1985 онд судлан буй сургаалыг зохиогдсон түүхэн үндэс, түүний үзэл санаа, зохиомж, монгол орчуулгын талаар авч үзсэн [5]. Доктор Т.Булган орчуулан, төвөд эхтэй нь хавсарган хэвлүүлжээ [1]. Бэрклэй Их сургуулийн дорно дахины хэлний тэнхим төвөд хэлээрх гар бичмэлийг хэвлэн нийтлүүлжээ [7]. Оросын монголч эрдэмтэн А.Д.Цендина 13-20 дугаар зууны буддын эр сурвалжийн талаарх тойм судалгаанд [9], Ш.Чоймаа хоёр ёсны сургаалын тухай өгүүлэлдээ дурджээ [10]. Ш.Бира, Г.Лувсанцэрэн, Г. Чулуунбаатар, А.Цанжид, Н.Сарантуяа, Г.Цэцэглэн зэрэг эрдэмтэн судлаачид хоёр ёсны талаар эртний Энэтхэг, Төвөдийн “номт хаадын сургаал”, “Төв үзлийн философи”, Ш.Л.Монтеско, А.Тойнби нарын үзэл санаатай харьцуулан судалжүзсэн байдаг. Бид энэ судалгаандаа “Хоёр ёсыг хосолсон улаан сувдан эрх хэмээх нэрт суртгаал” хэмээх монгол хэлнээ хөрвүүлсэн гар бичмэлийг шинжилж, үзэл санааны талаар тайлбарлахыг оролдож байна.

II. Судалгааны арга зүй

«Улаан сувдан эрх»-ийн судлагдсан байдлыг уран зохиол, эх бичгийн талаас болон үзэл санааны тухай гэж авч үзэх нь зүйтэй юм.

Хос ёсны сургаал, хоёр ёсны сургаал гэсэн өөр өөр томъёолол байдаг. Товчхондоо аливаа хүмүүний бие хийгээд сэтгэлийн чанарыг тусдаа ангид хэмээх буддын дотоод ухаан дээр үндэслэгдэн ертөнцийн буюу төрийн хэрэг хэмээх цаазын ёсон хийгээд сэтгэл санаа, шүтээн буюу шашин хэмээх соёлоор нь хослуулан удирдах Дорны ард түмний төрт ёсны уламжлал мөн. Үүнийг өнөөгийн удирдахуйн ухааны философи, ёс суртахууны зарчмуудтай дүйлгэн ойлгож болох юм. Эл судалгаанд эх бичгийн анализ, герменевтик арга зүйн зарчмуудыг баримтлав.

III. Судалгааны үр дүн

Хоёр ёс гэдэг ойлголтыг (англи хэл. dual principle, two principles, “two customs-khoiyar yosu” of religion and state) уран зохиол, шашин, философийн судалгааны бүтээлүүдэд янз бүрээр тодорхойлжээ. Тус сургаалын шүлэгт “Урьдын гарсан дээдсийн зам **хоёр ёсны цааз** нэн эзэгнэсэн” гэж мөр буй. Академич Г.Лувсанцэрэн “Хос ёс нь хууль цааз, цэргийн биет хүч, нөгөө талаас ухаан билиг, зан суртахууны сэтгэлийн хүч хоёрыг төрийн бодлогод нэгтгэн барих ёс. Эл хоёр хүчийг хослуулах нь төвч мэргэнээр харах төрийн бодлогыг иргэн ардаа билгийн хурц, сэтгэлийн энэрэнгүйд хүргэх буддын шашны номын ёстой хослуулах гэсэн хэрэг” [3] гэж үзжээ. Эрдэмтэн Л.Хүрэлбаатар “Бурханы шашин, хааны төр хоёрыг юугаар нь ялгаж таних вэ гэж асуусанд, багш нь хариулж хэлэхдээ: “Өөртөөн харгацсанаас, өөрийн сэтгэлийн үндсэнд буй арван нүглийг тэвчих нэгэн зүйл ёс зарчим буй, тэр нь бурхны шашин мөн. Өрөөлд харгацсанаас, арван нүглийг хорин тэвчүүлэх нэгэн зүйл засаглал буй, тэр нь хааны төр мөн. Энэ бол нэг нь дотроос нь засдаг, нөгөө нь гаднаас нь засдаг гэсэн үг. Өөрөөр хэлбэл нэг нь ухамсарлахад түшиглэдэг, нөгөө нь хүчирхийлэхэд түшиглэдэг гэсэн үг. Өөрөөр хэлбэл сайнд хөтлөх, саарыг тэвчүүлэх үйлийн хүрч нийлэх үзүүр нь хоёул адил, хүргэж аваачих хөлөг унаа

нь хоёул өөр гэсэн үг. Иймийн учир дээрээс шашин, төрийн “хоёр ёс”, “хос ёсны” агуу их үзэл санааг ихэрлүүлэн холбож, тэмцлийн зөөлөн хатуу хоёр аргаар, арга билгийн дотоод гадаад хоёр замаар хаадын төрийг бэхжүүлж, улсын засгийг явуулж ирсэн нь **монголчуудын шашин төрт ёсны асар их соёл** мөн. Энэ бол бурхны шашны ёс, төрийн ёс хоёрыг салгаж ойлгоод, нийлүүлж ухаарахын хэрэг төгс эрдэм мөн [6, 7].

Хоёр ёсны үзлийн талаар профессор Ш.Чоймаа “Хос ёсны сургаал хэмээхийг өнгөц хуудмаар зөвхөн шашин, төр хоёулыг тэгшид агуулах ёс хэмээн ухаарч үл болно. Энэ сургаал нь хаад , ноёд , түшмэд язгууртад, харц албат, лам хувраг алин нь ч хэмээсэн бие, хэл, сэтгэлээр үйлдэх аливаа үйлээ буян, нүглийн үр дагавраар шинжилж, сэтгэлээ ариусгахыг насад хичээж , авах гээхийн ухаанаар тунгааж, бас тус тусын язгуурын суртахуунаа сахиж явахыг сургасан явдал мөрийн цогц хөтөлбөр юм” гэж тодорхойлжээ.

Д.Цогтсайхан “Цагаан түүх”-ийн агуулгыг системчлээд “нягталбаас, ертөнцийн төр, номын төрийн хоёр ёсонг байгуулсан, шинэтгэн засаж явуулсан, даган хоцроолгүй тэгшид явуулсан, сайтар явуулж эрхэлсэн гэсэн дөрвөн үндэслэл байна”[12] гэж тодорхойлжээ. Г.Лхагвасүрэн “Бурханы шашны сургаалаар хүмүүнийг энэ ертөнцийн /сансарын/ зовлонгоос гэтэлгэгч их хөлгөний буюу судрын зам, нууц /очир/ хөлгөний буюу тарнийн зам хэмээгч хоёр мөр байх тул шашны төр нь тэр бүхнийг хамарсан судрын ба тарнийн хэмээх хоёр засагт, хааны төр нь ард олныг элбэрэн нигүүлсэх, энэрэн тэтгэхүйн үйлсийг эрхлэгч энх иөр, төрийн албадлага хүчирхийллийн үүргийг хэрэгжүүлэгч гилбэр буюу дайчин төр хэмээх хоёр хэсэгт тус тус ангилагдах ажгуу” [5] хэмээн номын төр хийгээд ертөнцийн төрийн үүрэг зорилгыг Буддын номлолын үүднээс болон ерөөс төрийн тухай сонгодог үзэл санаан дээр тулгуурлан онцолсон нь бий.

А.Цанжид бичихдээ “ хос суртаахуунт төр бол төрийн ирээдүй мөн. Хуулийг дээдлэх суртахуун, ёс суртахуун, хүмүүнлэг ёсыг дээдлэх суртахуун. Хос суртахууныг хэрэгжүүлэхийн тулд хууль, ёс суртахуун хоёрын аль алиныг төрийн арга хэрэгсэлээр дэмждэг байх хэрэгтэй. Хуулийг албадлагаар сахиулж, ёс суртахууныг гэгээрлээр дэмжинэ.” Хэмээн хоёр ёсны сургаал нь хууль цааз хийгээд ёс суртахууны хосолмол сургаал болохыг онцлоод “Дорнын ард түмэн, түүний дотор монгол төвдийн ухаантнууд хос ёсны сургаалыг буй болгосон” гэжээ[10].

Г. Чулуунбаатар “ Арван буянт номын цагаан түүх-д цэгцрэн боловсорсон энэ үзэл санаа монголын төр ёсны хувьд гүзгий уламжлалтай бөгөөд өрнө дахины теократ ёсноос зарчмын ялгаатай үзэл санаа юм” [6] хэмээн тодотгосон байдаг.

Христофер Этвүүд “Энэ үзэл баримтлал нь Өвөр Ази дахь эзэн хааны засаглалыг буддын шашинтай холбосон бөгөөд өглөгийн эзэн (төвөд хэлний yon-bdag) ба тахилын орны (төвөд хэлний mchod-gnas) ойлголттой холбоотой үзэл санаа. Буддын шашин (шашин) ба хаант засаглалын (төр) "хоёр ёс" нь гэр бүлгүй лам, гэрийн эзэн хоёрын хооронд нийгмийн хоёр үндсэн дэг журам харилцан уялдааг тогтоожээ. Хаан лам нарт өглөг өгснөөр тахилын оронд өргөнө. Хийдийн нийгэмлэгийн (сангха) сахилга батыг дагах, эс дагах хүмүүсийг хөөж гаргах. Тангудын Xia династ (1038-1227)-ын үеэс эхлэн хаан

тарнийн буддын шашны агуу бурхдын нэгэнд өргөмжлөгдөн мацаг барьж бясалгал хийхэд суралцаж лам багшийнхаа өмнө мөргөдөг байв. Эзэн хааны эрх мэдлийг хамгаалагчдыг цочирдуулж байсан ч тарнийн ёсны багш шавийн харилцаа нь “өглөгийн эзэн-тахилын орны харилцаа” болсон юм. Энэ зарлигийг дэмжигчид “хоёр ёс” ба “тахилын орон ба өглөг”-ийн харилцааг уламжлал болгон тарнийн ёсны багш нарын авшгийн залгамж болон хаадын угсаа залгамжлалтай холбосон уламжлал болсон. Зарим түүхэн бүтээлүүд Чингисийн угсааныхан өглөгийн эзэд, Төвөдийн хувилгаан Далай лам тахилын орон байх ёстой гэдгийг далд болон илэрхий маргалдсан. Энэ нь сүсэг бишрэлтэй хаан, чадвартай ламын дүрийг ашигласан ойлголт гэж үздэг [13]. Түүнчлэн “V Далай Ламын Нууц Тэмүүлэл” хэмээх намтар түүх цадигийн ойлбор судалгаанд тухайн үеийн Төвөдийн улс төр, шашны нөхцөл ялангуяа Далай ламын үүрэг нөлөө, шинэ засгийн газрын үйл ажиллагааны бодлого хийгээд хүндрэлийг тэр үеийнх нь геополитик, төр хийгээд шашны засаглал, хувь хүмүүсийн харилцаан дунд нь тодорхойлон гаргасан байдаг. Ялангуяа V Далай ламын улс төр-шашны бодлогын хамгийн ойрын хүн болох Дэсрид Санжаажамц (1653-1705) хийгээд Төвөдийн Засгийн газрын зүгээс Монгол оронтой харилцах шашин номын хийгээд улс төр, номт дипломатын бодлогын талаар нарийвчлан тодорхойлсон байдаг [18].

Энэ мэтчилэн V Далай ламын засгийн газрын Монголын хаадтай харилцах бодлого үйл ажиллагаанд авах гээхийн ухаанаар хандаж, улс төр, гадаад харилцаа, геополитикийн жич судалгаа дүгнэлтүүд хийх нь зүй. Хоёр ёсы үзэл бол наанадаж Хубилай хаан ба Пагба ламын үеэс, цаашилбал Их Нирун Улс (330-555)-ын төрийн багшийн түүхэн уламжлалтай хийгээд ерөөс Монгол төрт ёсны арга билиг, хууль цааз ба сэтгэл, үзлийг засах үзэл санааны агуулгатай болохыг дээр дурьдсан эрдэмтэн судлаачид онцлон үздэг. Мэдээж энэ бол гагц Монголын бус Дорны орнуудын төрт ёсны сургаалд дэлгэрэн тархсан, тухайлбал Буддын “Чакраварти хаан”-ы номлолын суурь нэгэн үзэл санаа мөн.

Бид энэнхүү өгүүлэлдээ V Далай ламын геополитикийн үзэл санааг юм уу ерөөс буддын шашин хийгээд төрийг засаглах уламжлал шинэчлэлийн асуудлыг бус харин хоёр ёсны сургаалын зарим зарчмыг менежментийн ёс зүйд хэрэгжүүлэх бололцоотой гэж онцлон үзэхийг хичээсэн.

Менежментийн ёс зүй бол байгууллагын үйл ажиллагааны хүрээнд үйлчилж буй хүний үйл хөдлөлийг хүн төрөлхтний ёс суртахууны нийтлэг шаардлагын үүднээс судалдаг чиглэл юм. Өөрөөр хэлбэл, удирдахуйн үйл ажиллагаа, хүнтэй харилцах, хамтран ажиллах, түншлэл, шийдвэр гаргахад баримтлах ёс суртахууны хэм хэмжээ, зарчмын цогц. Менежментийн философи нь байгуулага (хүмүүс)-ыг хамгийн үр ашигтайгаар хөтлөн чиглүүлэх удирдлагын онол аргазүйн зарчим, түүний үндэслэл ахуй танин мэдэхүй хийгээд ёс зүйн асуудлыг багтаасан удирдлагын аргын хийгээд үнэлэмжийн мэдлэг гэж хэлж болно.

Доктор Г.Лхагвасүрэн Өндөр гэгээний шашин, соёлын үйл ажиллагааны тухай судалгаандаа “Тавдугаар Далай ламын төрөл арилжих үеийн намтрыг Дэсрид Санжаажамц зохиосныг монгол хэлнээ хөрвүүлэхийг айлтгасанд Богд бээр хоёр гурван өдөрт орчуулан зохиогоод Манзушир эзэн хаанд өргөн барив гэж дурддаг. 1514 онд лозава Шалүгийн зохиосон төвөд хэл зүй, орчуулгын

алдарт толь болон Дэсрид Санжаажамцын зохиосон V Далай ламын намтрыг тус тус Өндөр гэгээн санаачлан удирдаж монгол хэлнээ хөрвүүлсэн нь тодорхой болж байна” [4] хэмээн дүгнэжээ. Намтар болон зарим төвөд сурвалжуудад V Далай лам Лувсанжамцын өлмий бататгахад зориулж Дэсрид Санжаажамцын бүтээсэн 225 боть Данжуурыг Монголд авч ирсэн тухай дурдаж байна [6]. Эдгээрээс үзвэл, судлаачид Монголд бурхны шашин дэлгэрсэн түүхэнд V Далай ламын намтар, үйл ажиллагааг тэмдэглэж иржээ.

Л.Хүрэлбаатар “Ялангуяа шинэ тулгар ном эрдмийн зүг оюун нээж байгаа залуу шавь нарт Жана Лодойжанцангийн “Тогмар ло-жон” /Thog mar blo sbyong/ хэмээх “Анхнаа оюун судлахуй”, Алагша лхарамба Агваандандарын “Мичой га-дон” /Mi chos dga, ston/ хэмээх “Хүмүүний номын баяр хурим”, Гүнтэн гэгээний “Ням-нён ган-бои вэлдам” /Nyams myong rgan po,i ,bel gtam/ хэмээх “Хал амссан өвгөний яриа”, “Шин-ги дан-чой” /Shing gi bstan bcos/, “Чуи дан-чой /Chu,i bstan bcos/ хэмээх “Модны шастир”, “Усны шастир”, V Далай лам Лувсанжамцын “Мүтил прэн-ва” /Mu thi la,i phreng ba/ хэмээх “Сувд эрих” зэрэг зохиолыг заавал үзүүлж, багш нь төвөд судраас нь монголоор орчуулан дуудаж, бас тэр явцдаа хэцүү хатууг нь тайлбарлан өгч, шавь нь ямар ч бичиг тэмдэглэлгүй багшийнхаа тэр судар барьж байгаад хэлсэн ая янзаар уг орчуулгыг тогтоон цээжилж авдаг байсан” [6] гэж уг сургаалын практик хэрэглээ, ач холбогдлыг үнэлсэн байна.

Оросын монголч эрдэмтэн А.Д.Цендина “Төвөд зохиолууд нь буддын итгэл үнэмшил голчилсон үзэл суртлыг тусгасан бөгөөд нэлээд хэмжээгээр гэгээрлийн утгатай, эдгээрийн нэг нь шашин, төрийн ёсны тухай хоёр ёсны шастирууд (төв. lugs zung gi bstan bcos- хос ёсны шаштир) гэдэг. Тухайлбал, Төвөд, Монголд алдартай V Далай лам Агваанлуvsанжамцын (1617-1682) “Хоёр ёсны сургаал сувдан эрих” (Lugs zung gi bslab bya mu thi' la'i 'phreng ba zhes bya ba bzhugs so) сургаалыг нэрлэж болно. Төвөдийн ийм эрих нэрт зохиолуудыг монголоор олонтаа орчуулагдсан. Тэдгээр нь гүр дуу, сургаал, оюуны дасгал зэрэг янз бүрийн хэлбэр, төрөлтэй”[9] гэж үзжээ.

Доктор Д.Дашпүрэв “Хоёр ёсны зарчим бол уг агуулгаараа философийн үзэл санааны дуализмын нэгэн өвөрмөц илэрхийлэл мөн боловч түүний нөгөө нэгэн илэрхийлэл болж байсан Чингис хааны улс төрийн бодлогын өвөрмөц тулгуур зарчим болж байсан хоёр хүрд буюу хос арлын зарчмаас агуулгын ялгаатай. Үндсэндээ буддизмын, түүний дотор их хөлгөний улс төрийн философийн хүрээнд багтана. Энэхүү зарчим нь Чингис хааны үеийн улс төрийн бодлогын тулгуур зарчмуудыг бүрэн халсны илрэл” [2] хэмээн дүгнэжээ. Эдгээр нь тус сургаалыг шашин, философи, улс төрийн үзэл санааны зарчим болох талаас янз бүрийн өнгө аястай дүгнэлт буйг харуулж байна.

Сургаалын бүтэц, агуулга: «Хос ёсны сургаал “Улаан сувдан эрих”» хэмээх сургаалыг зохиогдох шалтгааныг Халх Монголын Түшээт хан Гомбодорж эсвэл Чахундоржийн хүсэлтээр, монголчуудын хүсэлтээр гэсэн хоёр янзаар тайлбарлажээ. Тэгэхээр энэ нь төрийн хүний хүсэлтэд зориулсан нь илэрхий байна. Буддын ном бичлэгийн уламжлал дагуу тахил мөргөл, үндсэн хэсэг, төгсгөл хэсэгтэй.. Сургаалыг хүсэлт, гуйлтаар нэгэн хүнд зориулсан гэж буй боловч энэ нь ямар ч хүний дагаж мөрдөх ертөнцийн ёсны хэм хэмжээг авч үзсэн байдгаараа ач холбогдолтой.

“Чингисийн язгуур тэнгэрийн заяат хааны хоолойг үзэсгэлэнтэй еэ болгогч
Хоолойвч эрихийг чимэг дор зүүе” хэмээнээс төрийн түшмэд, алтан
ургийн хаадын удамд зориулан айлдсан нь тодорхой байна.
Тус сургаалын үндсэн хэсгийн агуулгыг шүүрдэн үзвээс дараах хэсэгт хуваан
ялгаж болно. Үүнд:

1. Менежментийн ёс зүйн суурь ойлголт нь байгуулагад шаардлагатай ур
чадвар, албан үүргийг “ажил үүргийн тодорхойлолт”-д нарийвчлан заах
явдал байдаг. Энэ бол ямар эрдэм, чадвар шаардлагатайг болон ямар хүн
ажиллах ёстойг удирдлагын ухааны үүднээс тодорхойлдог. “Мүтил
принвай”-д “мэргэн”, “сэцэн”, “гүн”, “хэрсүү”, “муу өчигт”, “сайн өчигт”
тэргүүтэнийг тодорхойлж, түүнийг таних ухааныг заажээ. Тухайлбал,
“Сэтгэлийн сэдвэр гарахуй дор хязгааргүй боловч
Хоолойд хүрч ирснээс үл өгүүлдэг тэр нь мэргэн мөн.
Зүрхийг хорсгогч дайсанд даруй уурлалгүй засаж инээснээр угтан
уулздаг нь цэцэн мөн
Өөрийн сэтгэлд зохимжгүй үг юу боловч
Худал сайхан загнасны санаагаа үл танигддаг гүн мөн
Идээ унданд дурлавч башир аргаар илэрхийлэлгүй далдуур авдаг хэрсүү
мөн
Муу өчигтийг бүү гонсойлго жич урваж болно.
Сайн өчигтийг бүү магт юу болохыг мэдэх бэрх” зэргээр заан нэрийджээ.
2. Харилцаа бол менежментийн болон ёс зүйн үндсэн агуулга, зарчим.
Сургаалд удирдагч хүн хэрэг, хурал шийдэхэд анхааран авах зарчим
болсон бусдыг сонсох, , үг хэлэх, дундаж, голчыг барих, хөвгүүн,
хатагтай, ноёд болон доорх албан тушаалтануудтай харилцах зарчмуудыг
голч, зарчимтай байх талаар дэлгэрэнгүй тусгажээ.
Сургаалд
“Хэний тэргүүнд багтахыг оньс үгүй тул бусдын хэлэнд хорлогдож
хэргийг бүү шийтгэ
Үйл аль ч бүтэх нь нотгүй тул амнаас яаран бүү гарга, дотроо нууваас
оньстой
Хөвгүүн тэргүүтэн саданд хайр нь хэтэрвээс муу зантай больюу.
Дайсанд нэн уурлаваас өөрт адил
Садан дор нэн сөргөцөлдвөөс алсдаа өстэй больюу
Боолд нэн бардваас хуурагдан чухаг
Нөхөрт нэн их ширүүдвээс элгэнд нь бэтэг чулуу орьюу
Нөхрийг басаж инээх нь олширвоос угаас гомдож,
Муу үлгэрийг бусдад өгвөөс өөрт эргэмүй,
Амаар дайсныг бүү хураа, хартай сэтгэлийг хатган,
Саданд бүү магт, асрах сэтгэлийг барь.
Хортой сэтгэл байвч гаднаа яруу зөөлөн өгүүл.
Нүүр тулан хатуу догшноор дайсныг номхотгох бэрх” хэмээгээд
“Зөвшилдөх эрхгүй хүнд үгээ бүү хэл, хутгалдан үйлдэгчийг зөвшлийн
сүрэгт бүү оруул
Мэргэд хийгээд хөгшид ба анзаарга сайтай халамжтайгаас асуу
Зөвшлийн тоймыг яаран бүү хэл урвуулж чадна.

- Дахин санаагаа нягталж олонтоо сэжиглэвээс хийгүй” гэж аливаа хурал, зөвшилцөл, шийдвэрийг гаргахдаа төвч чигч шугмыг баримталж олон талаас нь нягтлах ёстойг анхаарулсан байдаг.
3. Менежментийн философийн нэг асуудал нь удирдлагын оновчтой үйлдэл байдаг. Ерөөс философийн түүхэнд прагматик үйлдлийг чухалчилдаг чиглэл ч бий. Энэхүү Мүтил принвай зохиолд аливаа сайн муу үйлийг үйлдэх хийгээд эс үйлдэх сургаалыг хүний өөрийн төрөлх шинж чанар болон бурхан багшийн хутагтын дөрвөн үнэн, гурван суртгаал, үйлийн үр хийгээд сансарын зовлон болох урин мунхаг тачаангуйн гэмтэй нөхцөлд нь таацуулан шүтэлцүүлж харьцах, үйлдэх, шийдвэрлэх тухай олонтоо өгүүлсэн нь бий.
- “Зүрхний үгийг олон үгтнээс нуу.
Ярдаг хэртэй хошин үл даагчид тогтохыг тэвч.
Худал юманд хөтлөгдөн заргыг бүү үйлд.
Дуулгаваргүйд зөвшлийг тавих хийгээд үгийг авч ир гэх ба
Үл болохын үйлийг захирах, үл мэдэхэд ундууцан орхи
Ачийг дурдах нь олширвоос баясах энэрэх сэтгэлийг алдмуй.
Хэмжээлэх олширвоос садан ч харьж буцмуй
Бусдын зовлонг тавлаж бүү үйлд, өөрт ирмүй
Өөрийн жаргалыг бүү хөөсөрлө, бусдаар түүнд хариу хэмжмүй”
тэргүүтэн буддын ёс суртахууны сургаалын агуулга номлолын ертөнцийн үйл үйлдэлд оруулан хэрэглэх заавар чиглэлийг дэлгэрэнгүй айлджээ.
4. Менежментийн шийдвэр гаргах үйл явц нь удирдлагын үндсэн үйлдэл. Шийдвэр гаргах, харилцахад үг, түүнийг өгүүлэгч хийгээд өгүүлэхийн үйлдэл шалтгаан үрийг харилцагч бүрийд анхааран авахыг нэг бүрчлэн сургажээ. Сургаалд:
- “Үгэнд учир буй тул олон мэргэдийг хэс.
Тайван зөөлөн яруу үгсээр мэхэдсэнээс
Бусдын ухааныг аргаар шүүж нам дор буулга
Эс хэлбээс эцэг ч үл мэдэх тул илэрхий өгүүл
Эс засарваас хөвгүүн ч тоохгүй болох тул хэртэй зэмлэ
Эс зэмлэн сургаваас хэн ч үл мэдэх тул сайтар сурга
Эс сурваас садан ч үл эргэх тул урмыг нь тэжээж өг”.
5. Удирдлагын үйл ажиллагааны үндсэн зарчим бол хамтын зорилго, чиглэлээ тодорхойлж, түүндээ хүрэхийн тулд өөрт болон өрөөлд буй нөөц, чадамжуудыг ухаалагаар ашиглан, оновчтой тактиктэй харилцааг ончтойгоор хэрэгжүүлж, хүмүүсийг өөртөө татан идэвхижүүлж, улмаар итгэлийг олж, нэгэн үзүүрт үр дүнд хүрэхэд орших амой.
- “Өндөр омогтны хоригийг бүү уудал.
Санаа муутай ахар бодолтон лугаа нөхөрлөн бүү үйлд
Ууртай зөөлөн үгтэнд өөрийгөө хянаж яв
Хэрэггүй үгийг дахин дахин улиглахыг тэвч
Баялаг эдээ эдлэхийг мэдвээс жич арвижмуй
Ядуу хүн хураан нарийлж үйлдвээс өөрийн зовлон багасмуй
Үгүйрсэн боловч зовлонд дагаж үйлдсэнээс эр зааж үйлд
Эд буй үгүйд худал бүү хэл, бүгдээр мэдмүй

Муу хүн их үг буюу хэл жигшүүртэй болмуй
Нүүрэндээ цусгүй саданд хорлосноос ичгүүр сонжуурыг мэдэгч дайсан
дээр гэдэг

Итгэмжгүй ах дүү хийгээд эр, эмээс нуун чадагч оюун төгөлдөр нөхөр
лугаа нөхөрлөвөөс сайн” тэргүүтэн үйл хийгээд үйлдэхүйн зөв хийгээд
бурууг өөрийн эрх дуранд бус харин ч тус бүрийд гарах гэм, алдаа гарах
магадлалыг хаан болгоомжлуулж сургажээ.

6. Хаан хүн төрийг удирдахад есөн төрлийн **эндүүрэл** буйгаас сэрэмжлэх
хэрэгтэйг өгүүлэхдээ:

Гүн оюунтныг эргүү дөнгөд эндүүрэл буй.
Томоогүй хүнийг эрмэг цэцэнд эндүүрэл буй
Сүжиг сайн шавийг их худалчид эндүүрэл буй
Хурц ухаантныг ахар бодолтонд эндүүрэл буй
Чанар сайтыг товчгүйд эндүүрэл буй
Шударга хүнийг тэнэгт эндүүрэл буй
Засмал дүртнийг ариуханд эндүүрэл буй
Насад оюунаар оршсоныг худалд эндүүрэл буй
Худалчийг мэргэнд эндүүрэл буй...” болно.

Гэхдээ сургаалд хашир хянамгай байхыг сургахдаа ёс суртахууны зөрчилт
үнэлэмжийг эсвэл дотнотлон, хэрхэн эвийг олж, тодорхой нөхцөлд тохируулж
зайлсхийх аргыг сургамжилсан гэмээр мөртүүд ч байна. Жишээлбэл:

“Хортой сэтгэл байвч гаднаа яруу зөөлөн өгүүл,
Муу өчигтийг бүү гонсойлго жич урваж болно.
Сайн өчигтийг бүү магт юу болохыг мэдэх бэрх...
Үгсийн эхэнд мишилзэн уулз, сүүлдээ алгуураар ав
Хэрэгтэй утгад оночтой үгийг таацуулан өгүүл
Харамласан төдийгөөр идээ, эд хураах бэрх тул, зууг өгөөд мянгыг
ирүүл” гэсэн мөр байна.

Юань гүрний үеэс хос ёсны сургаалыг төрийн бодлогод шүтэн
барилдуулж, нарийн чанд тогтоосныг “Арван буянт номын цагаан түүх”-ээс
үзэж болно. “Цагаан түүх”-ийн үндсэн үзэл нь хос ёсны сургаал бөгөөд “Үнэн
хоёр ёсыг тэгшид эндүүрэлгүй явуулахуйн товчоон “Арван буянт номын
Цагаан түүх” хэмээн нэрлэн тодорхойлсон нь агуулгаа товчилсон мэт юм [10].
Энэтхэг, Хятад, Монгол, Төвөдийн уламжлалт хоёр ёсны сургаал нь цагийн муу
ирэхэд мартагдан дарагдаж буйг тодлон:

Эдүгээ энэтхэг, хятад, монгол, төвөд тэргүүтэн
Урьдын гарсан дээдсийн зам хоёр ёсны цааз нэн эзэгнэсэн
Муу явдлын хөөрөлд автсан цаг үүн дор
Сайн номлол ч Зүдийн оронд хоёр хөлт мэт¹ хэмээсэн болно.

Буян, сайн үйлийг арвижуулахад номын ба ертөнцийн үйлийг ёсоор явуулах нь
зүйтэй болохыг

¹ Зүдийн оронд нэг хөлт хүмүүн байдаг гэж домог өгүүлдэг. Өрөөсөн хөлт зүда* хэмээх төрөлтөн
амьдардаг тивд Замбуутивийн хоёр хөлт хүн очвол эрэмдэг, зэрэмдэг хэмээн шоолдог гэдэг
бөгөөд цөвүүн цагт билгүүн номт хүн нийгэмдээ ад үзэгдэхийг ёгтлон хэлжээ.

“Бурханы ном байтугай ертөнцийн үйлэдбэрийг ч ёсоор болох нь
Буянд гавьяархах тул, чухаг дээдийг тахих гээд хулгайчид өглөг өгөх
тэргүүтэн

Сайн үйлийг арвидахын их чуулганыг хурааваас оньстой” хэмээжээ.

Муу үйлийн үрийг “Муу үлгэрийг бусдад өгвөөс өөрт эргэмүй” гэснээр
илэрхийлжээ.

Хөвгүүн, дайсан-нөхөр, садан-боол, өөрөө гэсэн ёс суртахууны
субъектүүдтэй зохистой харилцах эрдэм, арга барилын талаар өгүүлсэн бөгөөд
өс санах, уурлах, хайрыг хэтрүүлэх, басамжлах, гомдох, бардах, зэмлэх,
өөрийгөө магтах, хүсэл шунахыг цээрлэх ёстой юм. Үүнд:

Хөвгүүн тэргүүтэн саданд хайр нь хэтэrvээс муу зантай больюу.

Дайсанд нэн уурлаваас өөрт адил

Садан дор нэн сөргөцөлдвөөс алсдаа өстэй больюу

Боолд нэн бардваас хуурагдан чухаг

Нөхөрт нэн их ширүүдвээс элгэнд нь бэтэг чулуу орьюу

Нөхрийг басаж инээх нь олширвоос угаас гомдож...

Хөвгүүнд зэмлэн донгодвоос сүүлдээ тустай

Өөрт магтахыг тэвчвээс алсдаа үнэтэй.

Өөрийн хүсэл шуналыг орхи, олонтой тэврэлдэхийн тулд үйлдэх ба
ариутга... гэжээ.

Ертөнцийн явдалд сонор сэрэмжтэй, анхаарамжтай байхыг өст муу хүнд
оюунаа бүү итгэ, хайрт эдийг хүсэлт хүнд үзүүлэлгүй нуу, зүрхний үгийг олон
үгтнээс нуу, худал юманд хөтлөгдөн заргыг бүү үйлд зэргээр сургасан нь аливаа
удирдахуйн үйлд хэрсүү чанар чухал болой.

Сургаалд орон цаг, ахуй үестэй зохицуулан дайсан садныг ялган
шинжлэгчийг шилдэг хүн (7-р бадагт), санаанд эс ургасныг дэмий өгүүлэгчийг
мэргэн (8-р бадагт), ачилсан хүнийг эс уйдуулагчийг цэцэн (3-р бадагт), алив
ажлыг чадамгайлан хийгчийг боолын дээд, амны үг цөөн гар ариуныг эрдмийн
дээд (33-р бадагт) мөн гэж өгүүлжээ [5].

Ертөнцийн хүмүүн бие, хэл, сэтгэлийн муу үйлийг хориглон тэвчих номын
ёсыг заан сургахдаа:

“Хэлсэн бүгдийг үнэнд бүү барь, шинжилж үйлд.

Идээний амттайг хүнд өг, эдийн сайныг өөрөө хадгал.

Хүнийг зүрхнээс өширхөх үгийг зүрхнээс барь

Ууртай дайсны эдийг бүү хар, умаргаж орхи

Амтгүй дор хамраа шантайлгаж, амтганд ховдоглох ба

Үл оршоосон даруйд хөмхийгөө зууж, нүдээ таглан тэвч хэмээжээ.

Эс хэлбээс эцэг ч үл мэдэх тул илэрхий өгүүл” хэмээжээ.

Эс сурах, эс засрах явдлыг зэмлэх, сургах, урмаар тэжээснээр тодорхой үр
дүнд хүрэх бололцоотойг

Эс засарваас хөвгүүн ч тоохгүй болох тул хэртэй зэмлэ

Эс зэмлэн сургаваас хэн ч үл мэдэх тул сайтар сурга

Эс сурваас садан ч үл эргэх тул урмыг нь тэжээж өг” [14] гэсэн байна.

IV. Хэлэлцүүлэг

Хоёр ёсны сургаал нь тухайн цаг үедээ төрийг удирдахуйн үндсэн зарчим байсныг хүлээн зөвшөөрдөг бөгөөд Хубилай цэцэн хааны шинэчлэлийн бодлогын нэгэн тулгуур үндэслэл болсныг тэмдэглэсэн байдаг. Нөгөө талаар, зарим судлаач энэхүү сургаал бол шашны хатуу догматик улс төрийн бодлого төлөвшихөд нөлөөлж, улмаар нийгмийн түүхэн үр дагавар нь дундад зууны монгол төрийн хувирал өөрчлөлтөөр илрэн гарсан гэж үздэг [2].

Бидний хувьд хоёр ёс нь ямар нэг нөлөөлөх үйлдэл хийхдээ хариу үйлдлийн хүчийг тооцох, орон зайг мэдэрч шийдэх, бусдад хүндэтгэлтэй хандах, туйлшрахгүй байх зэрэг менежментийн ёс зүйн зарчим мэт болно. Энэ утгаараа түүхэн тодорхой цаг үед улс төрийн бодлогын зарчим болж байсныг тодотгоод, буддын шашин соёлт орнуудад бурхны шашны үзэл номлолыг эгэл хар хүмүүст буюу орчлон хэмээх муу үйл дэлгэрэх ёзоорт ертөнцийн аж төрөх, харилцах, хамаарах нийтлэг хэм хэмжээнд хэрхэн баримтлах боломжтойг илэрхийлсэн ер нийтийн сургаал ажээ.

Бэрхшээн залхайрч сул тавихын эрхэд орвоос сайн эрдэм алин ч бүтэх бэрх тул

Алжаалгүй их хичээнгүйгээр шамдан үйлдвээс нэн их хэрэг үйл ч өөрөө бүтмүй

Түүнчлэн ирсэн бие тэргүүтэнд зорин сэтгэснээс

Алагсалгүй чиглэсэн бат самадийн үргэлжлэлийг таслалгүй залгаваас

Нисваанисын ялагч болохын тэргүүн нь сүрээр дарж

Бие, сэтгэл эелдэг болохын даяаныг олмуй” хэмээн Бурхан багшийг тэргүүлсэн бат итгэлтэй, өөрөө хичээн оролдож, хичээн оролдох цагт бие, сэтгэл, эрдэм оюун ашид дэлгэрэх хувьтай хэмээн итгэл сүжгээр дамжуулж иргэний ёс суртахууны үзэл санааг агуулсан байна.

V. Дүгнэлт

V Далай ламын амьдрал үйл ажиллагаа нь улс төр-түүхэн нэн эгзэгтэй үед явагдаж байснаараа олон талын судалгаанд сонирхолтойгоор тусгагдсан байдаг. Ялангуяа тухайн үеийн геополитикийн адармаатай орон, цаг дор Төвөд-Монголын харилцаанд түүхэн бие хүмүүсийн гүйцэтгэсэн улс үндэстэнийхээ хийгээд шашин номын эрх ашиг, сонирхол харилцан адилгүй үнэлэмж, дүгнэлтийг бий болгодог. Юутай ч энэхүү өгүүлэлээр V Далай лам Лувсанжамцын айлдсан “Сувдан эрхи” хэмээх хоёр ёсны сургаалыг өнөө хүртэл манай ард иргэд, малчид шүтэн дээдэлж, лам нар анхны сургаал зохиолтой танилцахдаа ашиглаж ирсэнийг анхааран энэхүү зохиол дах үзэл санаанаас иргэний агуулгатай, бүр тодруулбал менежментийн философийн гэмээр, ёс зүйн агуулгуудыг тодотгон авч үзлээ.

Ашигласан материал

1. Булган Т. (2017). Буддын ёс зүй, гүн ухааны суртгаалын эмхэтгэл. “Соёмбо принтинг” ХХК.
2. Дашпүрэв Д. (2017). Монгол нийгэм. Сэлэнгэ пресс ХХК. Уб., 113, 115 дахь тал
3. Лувсанцэрэн Г. (2008). Буддын гүн ухааны онол, түүхий асуудлаас, “Бемби сан” ХХК. Уб., 295 дахь тал
4. ФСЭХ. ШУА. (2001). Монголын философийн түүх. Боть 3, “Бемби сан” ХХК. Уб., 151 дэх тал
5. ФСЭХ. ШУА. (2000). Монголын философийн түүх. Боть 2, “Бемби сан” ХХК. Уб., 263, 25, дахь тал
6. Чулуунбаатар Г. (2009). XX, XXI зууны зааг үеийн Монголын улс төрийн өөрчлөлт, ардчиллын хөгжил ШУА, Философи, социологи, эрхийн хүрээлэн. “Бемби сан” ХХК. Уб., 133, 13, 22 дахь тал
7. Хүрэлбаатар Л. (1989). Сувд эрх хэмээх зохиолын тухай, Түүхийн судлал. Уб., 21-34 дэх тал
8. Хүрэлбаатар Л. (2002). Судар шастирын билиг. Уб.,
9. Mu-thi-la'i phreng ba; Mes po'i zhal-lung. Two didactic poems written by the fifth Dalai Lama, 1617-1682, editor by the Ven. DaLama Namgyal Dorje. p.76
10. Sam Staggs. (2009). Born to Be Hurt: The Untold Story of Imitation of Life. New York: St. Martin's Press. pp. 31-32, 84, 7
11. Цанжид А, Дэлгэржаргал Ц. (2019). Хос суртахуунт төр. “Соёмбо принтинг ХХК.
12. Цендина А.Д. (2013). О дидактической литературе монголов (XIII-середина XX века). Монголика –XI, St Peterburg., стр. 204
13. Чоймаа Ш. (2010). Хос ёсны сургаалаар төрөө засаж ирсэн уламжлал. 558 дахь тал <https://www.sinoss.net/uploadfile/2010/1130/9759.pdf>.
14. Цанжид А, Дэлгэржаргал Ц. (2019). Хос суртахуунт төр. Ред. Отголжий С. “Соёмбо принтинг” ХХК. Уб.,
15. Цогтсайхан Д. (1998). Хубилай хааны тогтоосон хоёр ёсон, Соёл иргэншил: гүн ухаан, хөгжил. 21-34 дэх тал
16. Christopher P. Atwood. (2004). Encyclopedia of Mongolia and the Mongol empire. Facts on file, Inc.

Сурвалж:

17. Хоёр ёсыг хосолсон улаан сувдан эрх” хэмээгдэх нэрт суртгаал оршивой. Гар бичмэл
18. Secret Visions of the Fifth Dalai Lama: The Gold Manuscript in the Fournier Collection. edit. Samten Gyaltzen Karmay., SERINDIA PUBLICATIONS, 1988. pp. 24-27
19. Хос ёсны сургаал улаан сувдан эрх оршвой. (2017). Буддын ёс зүй, гүн ухааны суртгаалын эмхэтгэл. Орч. Булган Т. Уб., 276-277 дахь тал.

ТАЛАРХАЛ: “Хоёр ёсыг хосолсон улаан сувдан эрх” хэмээгдэх нэрт суртгаал оршивой”, “Ёс хоёрын суртгаал сувдан эрх оршуулсан болой” гар бичмэлийн эхийг өвөг дээдсээсээ өвлөн хадгалж, бидний судалгаанд дэмжлэг үзүүлсэн Архангай аймгийн Эрдэнэбулган сумын иргэн Ч.Алтанчимэгт гүн талархал илэрхийлье.

Нэр: “Хоёр ёсыг хосолсон Улаан сувдан эрих хэмээгдэх нэрт суртгаал оршивой”

Зохиогч:

Агваанлуvsанжамцжигмэдгочоотүвдэн
/1617-1682/

Цаасны хэмжээ: 24x26.5

Мөрийн тоо: 160

Хуудасны тоо: 8

Цаас: муутуу

Номын хэв: гар бичмэл

Бичгийн хэрэглэл: бийр

Номын хэлбэр: үдмэл

Юугаар бичсэн: хар бэх

Зохиосон он цаг: 17-р зуун

Эхлэл хэсэг: Өгүүлэх хэлний эрх баялаг
Манзушир...

Төгсгөл хэсэг: Содномжамц алдарт далай
лам тэр заларснаас эдүгээ хүртэл шажин
төгс төгссөний учир шалтгаан тиймийн
тул зөөлөн итгэл Богд Зонховын...

Дутуу мөрийн тоо: 18

Хаана хадгалагдаж буй: Архангай
аймгийн иргэн Ч.Алтанчимэг, 57 настай.

Тамга тэмдэг: Үгүй

Бичээч: Пунцагванбу

Нэмэлт тайлбар: Сүүлийн хуудас
урагдаж үгүй болсон.



**ХОЁР ЁСЫГ ХОСОЛСОН УЛААН СУВДАН ЭРИХ
ХЭМЭЭГДЭХ НЭРТ СУРТГААЛ ОРШИВОЙ***

Өгүүлэх хэлний эрх баялаг Манзушир
 Эгшиглэнт охин тэнгэр шастираар хүслийг хангагч
 Цог төгөлдөр эсруа дөрвөн аймгийн гуу санг баригч.
 Дэлхий дахиныг эрхшээх эзэн нугуудаар өлзийлөн оршьё
 Шажин төрийн үгийн утгыг гүн төлөвлөсөн дуу
 Ёгт үгээр ятгалд оруулан дуулах бөгөөс
 Тийн шинжлэхийн ид заль дэлгэрсэн ухаан төгөлдрийн чихэнд
 Яруу боловч олонхын чихэнд үрэгдэн тарж тэрлүүлсэн мэт
 Тийм тул дээд доод бүгдээр сайтар ухах
 Шулуун номлолыг шүлэглэсэн улаан сувд
Чингисийн язгуур тэнгэрийн заяат хааны хоолойг үзэсгэлэнтэй еэ болгогч
 Хоолойвч эрихийг чимэг дор зүүе.
 Эдүгээ энэтхэг, хятад, монгол, төвөд тэргүүтэн
 Урьдын гарсан дээдсийн зам **хоёр ёсны цааз** нэн эзэгнэсэн
 Муу явдлын хөөрөлд автсан цаг үүн дор
 Сайн номлол ч Зүдийн оронд¹ хоёр хөлт мэт.
 Умар хандсан нүхэнд нарны гэрэл үл орох
 Бодит жам ёсонд засалтгүй болбоос
 Зүг бус нүхэнд орсон гэгээ гэрлээр
 Балар харанхуйг арилгаж, заримдаа болох буюу хэмээн,
 Бурханы ном байтугай ертөнцийн үйлэдбэрийг ч ёсоор болох нь
 Буянд гавьяархах тул, чухаг дээдийг тахих гээд хулгайчид өглөг өгөх тэргүүтэн
 Сайн үйлийг арвидахын их чуулганыг хурааваас оньстой.
 Зөн мэдэлгүй тулд зөвшөөсөн хэрэг бүгдийг хүлээн авах бэрх
 Оройн цагийн ахуй үес хийгээд дайсан, садан дунджийг ажиглаж даруй хэрийг
 нь таньж, аваад ордог нь эрмэг хурц мөн.
 Сэтгэлийн сэдвэр гарахуй дор хязгааргүй боловч
 Хоолойд хүрч ирснээс үл өгүүлдэг тэр нь мэргэн мөн.
 Зүрхийг хорсгогч дайсанд даруй уурлалгүй засаж инээснээр угтан уулздаг нь
 цэцэн мөн
 Өөрийн сэтгэлд зохимжгүй үг юу боловч
 Худал сайхан загнасны санаагаа үл танигддаг гүн мөн
 Идээ унданд дурлавч башир аргаар илэрхийлэлгүй далдуур авдаг хэрсүү мөн
 Муу өчигтийг бүү гонсойлго жич урваж болно.
 Сайн өчигтийг бүү магт юу болохыг мэдэх бэрх.
 Хэний тэргүүнд багтахыг оньс үгүй тул бусдын хэлэнд хорлогдож хэргийг бүү
 шийтгэ

* Энэхүү гар бичмэлийг Архангай аймгийн иргэн Ч.Алтанчимэг хадгалж буй болно.

¹ Зүдийн оронд нэг хөлт хүмүүн байдаг гэж домог өгүүлдэг. Өрөөсөн хөлт зүда* хэмээх төрөлтөн амьдардаг тивд Замбуутивийн хоёр хөлт хүн очвол эрэмдэг, зэрэмдэг хэмээн шоолдог гэдэг бөгөөд цөвүүн цагт билүүн номт хүн нийгэмдээ ад үзэгдэхийг ёгтлон хэлжээ.

Үйл аль ч бүтэх нь нотгүй тул амнаас яаран бүү гарга, дотроо нууваас оньстой
Хөвгүүн тэргүүтэн саданд хайр нь хэтэрвээс муу зантай больюу.
Дайсанд нэн уурлаваас өөрт адил
Садан дор нэн сөргөцөлдвөөс алсдаа өстэй больюу
Боолд нэн бардваас хуурагдан чухаг
Нөхөрт нэн их ширүүдвээс элгэнд нь бэтэг чулуу орьюу
Нөхрийг басаж инээх нь олширвоос угаас гомдож,
Муу үлгэрийг бусдад өгвөөс өөрт эргэмүй,
Амаар дайсныг бүү хураа, хартай сэтгэлийг хатган,
Саданд бүү магт, асрах сэтгэлийг барь.
Хортой сэтгэл байвч гаднаа яруу зөөлөн өгүүл.
Нүүр тулан хатуу догшноор дайсныг номхотгох бэрх,
Элдэв зүйл аргаар хэргийн алцанаар шийтгэ,
Үгсийн эхэнд мишилзэн уулз, сүүлдээ алгуураар ав
Хэрэгтэй утгад оночтой үгийг таацуулан өгүүл
Харамласан төдийгөөр идээ, эд хураах бэрх тул, зууг өгөөд мянгыг ирүүл
Ер тэвчихийн оюуныг уужим тавь
Хөвгүүнд зэмлэн донгодвоос сүүлдээ тустай
Өөрт магтахыг тэвчвээс алсдаа үнэгэй.
Өөрийн хүсэл шуналыг орхи, олонтой тэврэлдэхийн тулд үйлдэх ба ариутга
Хатагтайн сургаалт эрхийг бүү өг, өөрөө шийд
Мунхагтай зөвших хийгээд мууд эрх бүү өг
Зөвшилдөх эрхгүй хүнд үгээ бүү хэл, хутгалдан үйлдэгчийг зөвшлийн сүрэгт
бүү оруул
Мэргэд хийгээд хөгшид ба анзаарга сайтай халамжтайгаас асуу
Зөвшлийн тоймыг яаран бүү хэл урвуулж чадна.
Дахин санаагаа нягталж олонтоо сэжиглэвээс хийгүй
Хууль дүрмийг өөрт нууснаас нягтлан шингээ,
Өчүүхэн олзыг хурааснаас гэм алдал хийгээд муу үгийг үл тогтоон
Хүсэл дор шуналаар гутмуй
Дээдсийг цагаар хэвчээлж доор буулгаж бүү үйлд.
Доодсыг их болговоос шинийг хөшүүрдэж
Мэргэдийг дэмий орхивоос эрдэм төгсөх чухаг
Олон хүнийг дайсанд бүү ав, саданд ирүүл.
Үл бүтэх олныг амлан бүү ав, түүнд бүү ор.
Хайрт эдийг хүсэлт хүнд үзүүлэлгүй нуу.
Хэр хэмжээгүй даврах өст муу хүнд оюунаа бүү итгэ.
Зүрхний үгийг олон үгтнээс нуу.
Ярдаг хэртэй хошин үл даагчид тогтохыг тэвч.
Худал юманд хөтлөгдөн заргыг бүү үйлд.
Дуулгаваргүйд зөвшлийг тавих хийгээд үгийг авч ир гэх ба
Үл болохын үйлийг захирах, үл мэдэхэд ундууцан орхи
Ачийг дурдах нь олширвоос баясах энэрэх сэтгэлийг алдмуй.
Хэмжээлэх олширвоос садан ч харьж буцмуй
Бусдын зовлонг тавлаж бүү үйлд, өөрт ирмүй
Өөрийн жаргалыг бүү хөөсөрлө, бусдаар түүнд хариу хэмжмүй

Гэмт үгийг илрүүлэн бүү үйлд, хойшдоо хэрэггүй
Хор хөдөлгөх үгээр дайсныг ирүүлэх,
Чандын санааг онохын тулд өнөд шинжилснээс
Өөрийн тэргүүнээ өндийлгөгч уран ухаантан цэцэн мөн
Ихэст хүрэхийн цагт дээрэнгүй хийгээд омгоо намдаа
Бүгдээр хүндлэхийн цагт дурамжхан нам явбаас амар гэдэг.
Бүтэх бүгдийг бүү үйлд, сайтар ажиглан алдаа хонжоог сана.
Ноён болох цагт хүслээ багасга
Ерийг хайрлахын талаас тухай дадсан нугуудыг үл илрүүлэн далдуур тэтгэ.
Мэдүүлсэн бүгдийг гартаа бүү ав,
Авснаас хойш амарлихуй догшин аргаар хэргийн эцсийг цайлга
Хэлсэн бүгдийг үнэнд бүү барь, шинжилж үйлд.
Идээний амттайг хүнд өг, эдийн сайныг өөрөө хадгал.
Хүнийг зүрхнээс өширхөх үгийг зүрхнээс барь
Ууртай дайсны эдийг бүү хар, умартаж орхи
Амтгүй дор хамраа шантайлгаж, амттанд ховдоглох ба
Үл оршоосон даруйд хөмхийгөө зууж, нүдээ таглан тэвч
Хэрэггүй улигт хичээвээс өөрөө алжаах мөн
Алах, цохих магадтай хэрэгт зүрх бүү шантар
Бантах магадтай алба хийгээд гарын бэлгийг саатуулан үйлд
Хэрэггүй албат нугуудыг нэрмэх үйлийг бүү үйлд
Хүнтэй уулзсан даруйд танилцах хийгээд ханилсан даруй оюунаа даатгах ба
Сэтгэлд таарсан даруй баясан инээх хийгээд үл таарсан даруйд
Царайгаа хураах нугууд томоогүй мөн
Сайн нь сайндаа хөөрөн эс мэргэжвээс алсдаа гутмуй
Амраг нь амрагтаа хөөрөн эс мэргэжвээс алсдаа өшилмүй
Мэргэн нь мэргэндээ хөөрөн эс мэргэжвээс алсдаа мунхарью
Ариун нь ариундаа хөөрөн эс мэргэжвээс алсдаа цалгайрюу
Ихэс нь ихэстээ хөөрөн эс мэргэжвээс эцэстээ доройтюу
Үгэнд учир буй тул олон мэргэдийг хэс.
Тайван зөөлөн яруу үгсээр мэхэдсэнээс
Бусдын ухааныг аргаар шүүж нам дор буулга
Эс хэлбээс эцэг ч үл мэдэх тул илэрхий өгүүл
Эс засарваас хөвгүүн ч тоохгүй болох тул хэртэй зэмлэ
Эс зэмлэн сургаваас хэн ч үл мэдэх тул сайтар сурга
Эс сурваас садан ч үл эргэх тул урмыг нь тэжээж өг.
Дахин дахин өгсөн газар өглөгч одвоос шууд болмуй
Ачит хүн түүний сүүл үл оруулагч цэцэн мөн.
Шилэн дээгүүр харайгч дайсныг хөшөөрүүлж бүү үйлд
Хэн бээр туслах садангүй, бэлгүй өчүүхнийг ганд нь бүү орхи
Алин захирсныг орлон чадах бөгөөс боолын эрхэм
Худал хийгээд башир аргыг эс мэдвээс алсдаа үнэтэй.
Ам цөөн, гар ариун үйлтэн эрдмийн дээд
Үйлдсэндээ их туниваас үйлдбэрт тогтоох нь буурмуй
Амаа ангайн, гараа атгагч хүн лугаа ханилбаас гутмуй
Өндөр омогтны хоригийг бүү уудал.

Санаа муутай ахар бодолтон лугаа нөхөрлөн бүү үйлд
Ууртай зөөлөн үгтэнд өөрийгөө хянаж яв
Хэрэггүй үгийг дахин дахин улиглахыг тэвч
Баялаг эдээ эдлэхийг мэдвээс жич арвижмуй
Ядуу хүн хураан нарийлж үйлдвээс өөрийн зовлон багасмуй
Үгүйрсэн боловч зовлонд дагаж үйлдсэнээс эр зааж үйлд
Эд буй үгүйд худал бүү хэл, бүгдээр мэдмүй
Муу хүн их үг буюу хэл жигшүүртэй болмуй
Нүүрэндээ цусгүй саданд хорлосноос ичгүүр сонжуурыг
Дээд төгс сайн явалтны боол жаргалтай гэлээ.
Махчин сурсан хулгай хүний сүрэгт бүү оруул
Гүн оюунтныг эргүү дөнгөд эндүүрэл буй.
Томоогүй хүнийг эрмэг цэцэнд эндүүрэл буй
Сүжиг сайн шавийг их худалчид эндүүрэл буй
Хурц ухаантныг ахар бодолтонд эндүүрэл буй
Чанар сайтыг товчгүйд эндүүрэл буй
Шударга хүнийг тэнэгт эндүүрэл буй
Засмал дүртнийг ариуханд эндүүрэл буй
Насад оюунаар оршсоныг худалд эндүүрэл буй
Худалчийг мэргэнд эндүүрэл буй
Тэр мэт энэ насны хэргийг бүтээхэд авах ухаарахын гэм, эрдмийг сайтар
мэдсэнээс
Баатар цэцэн хүчтэн элдэв зүйлийн хүчээр
Мөнхүү өөрийгөө ялахын арга залиг эрхлэн авах хэрэгтэй
Тийн мэдэлт эсрэн, хурмаст, загарбард, тэнгэр, хүний цог учралыг бүрэн
эдэлсний эцэст
Жич бас улайдсан газар дэлхийд тамын гал бадарсны түлж больёу
Болохыг батлах юун
Ертөнцийг гийгүүлэгч наран саран ч урьдын хураасан сайн үйлийн хаягдал
барагдсаны эцэст
Өөрийн гар, хөлийг жийх хумихыг үл үзэн
Харанхуй оронд хэвтэж нулимсыг цувруулмуй
Лянхуа навч мэт хувцас өмсөвч биед нь ширүүн хэмээн үйлдэгч үзэсгэлэнт
охин
Эзний хүүр лугаа хамт улайдсан байшин
Бадарсан галаар түлэгдэхэд хэн бээр тэсэх
Эрдэнийн тивд очсон худалдааны өлгөөр
Базарваань лугаа тэмцэх сартваахь ч
Зангирсан хоолойд орон төрснөөс идээ ундаагаар ундаасахуй аяа халаг
Дайсныг номхотгож, садныг тэтгэх ган сан төгс ядам тэргүүтэн
Дээш дээш арвидсан их эрмэг цэцний тоонд багтавч
Нас нь огторгуйн цахилгаан мэт
Зүүдэн төдий амгалангаар юуг үйлдэх
Санасаар хэзээ ч худал хэлэх огт үгүй ба
Бурхан багш тийн удирдагч Шудоданы хөвгүүн тэрээр
Орчлонд оршсоноос хойш зовлонгийн мөн чанарыг үзүүлсэн ёсыг санаваас

Зүрх ч ангид хагарахуй мэт
Тэсэхэд бэрх зовлон үүнээс дээш үл няцах тонилохын ордонд орохын арга нь.
Хар цагааны үйлийн үрийг санаснаас авч оршихын талаас гурван сургаалыг
анхааран авдаг нь цэцэг мөн
Бурхан бодьсадыг илт үзэх бэрх боловч тэдгээрийн гэгээнийг /нүүрийг/ орлох
зарлиг хийгээд тогтоол шүтээнд цэцэг, хүж, зул, сайн идээ, хөг дуу
Банжид /манжлага/, түгчим /шүхэр/, бурам тэргүүтэн тахилын чуулганыг эрэх
Гурван сургаал төгөлдөр хуваргыг өргөн хүндэлснээс
Бурхны зарлигийг дуурьсах тэргүүтэн номын арван зүйлийн явдлаас
Гурван зүйлийг хүрдэн үйлийг ахуй арвижихуйн буяны их чуулганыг хураах их
оньстой
Үгээгүй ядуу төрөлхтөн бүгдэд өглөг өг
Ядмаг өвчтөнийг идээ, хувцас, эмээр тэтгэ
Муу үгээгүй ядуус ба алах зохистой ялтан хүний амийг зольж үл айх авралын
өглөгийг өг
Тэнгэр хүмүүний сайн шүтээнийг олохын шалтгаан нь эрхэмлэл
Үлдэх хялбар төвөг багатай найман гишүүт шагшаабадыг
Шинийн найман, арван таван, битүүн нугуудад сайтар авснаас
Ам авсан санваарыг ёсчлон сахин үйлд
Ширүүн үгсийн мэсэд үл салгаж, бөх хуяг өмсвөөс өөрийн үндсийг үл хямрах
тул
Тийн цагаан буяны амин судсыг үл таслах бөгөөд урьдын хураасныг
арвитгахын арга ёс үүнд хичээ
Бэрхшээн залхайрч сул тавихын эрхэд орвоос сайн эрдэм алин ч бүтэх бэрх тул
Алжаалгүй их хичээнгүйгээр шамдан үйлдвээс нэн их хэрэг үйл ч өөрөө бүтмүй
Түүнчлэн ирсэн бие тэргүүтэнд зорин сэтгэснээс
Алагсалгүй чиглэсэн бат самадийн үргэлжлэлийг таслалгүй залгаваас
Нисваанисын ялагч болохын тэргүүн нь сүрээр дарж
Бие, сэтгэл эелдэг болохын даяаныг олмуй
Ном нугууд тус нэрийдэхийн шүтээн нь дээр төдий бөгөөд
Ухаанаар нэрийдсэнээс бус үнэмлэхүйд үл олдон
Садан барилдахуйгаас болсон төв мөрийн бэлгийн мэсээр
Орчлонгийн язгуурыг тасалмуй
Дурдсан төдийгөөр өгүүлэн эзний өмгийг дарагч Аюуш бурхан.
Чөтгөрийн аймаг сэлтийг доройтуулан үйлдэгч нууцын эзэн
Лам лугаа ялгалгүй зургаан мутарт Махгал
Энэ хойд зуурдын аврал мөний тул насад шүттүгэй
Тэр ч огторгуй хийгээд дэлхий хот мандал дор
Эрх баялаг хүний их хаад гагцхүү өөрийнхөө буяны барилдлагад цолойдсоноос
/чиглэснээс/
Шашин, амьтан нь амаржихын аргыг бүтээхэд дээдэд сайшаамуй
Аливаа газрын их хаад лугаа янагш чинагш элгэн найрамдаж асрах сайн
сэтгэлтэй
Өөр өөрийн харьяат аймгуудаар бүл мэдэж
Бүгд албат ба бүрэн нь амаржуулахын тул сайн их гол ёсыг арвижуул

Бурхны нигүүлсэхүй алагчилгүй амьтанд оруулахын тул үнэхээр ном до алагчлалгүй

Эртний цагаас дэлгэрсэн эцэг өвгийн номын ёсон төв таалал тэр маш өлзийтэй Умар зүгийн Их Монголын хааны дэлхий дахинд Алтан номун хааны оройн лам Содномжамц алдарт далай лам тэр заларснаас эдүгээ хүртэл шажин төгс төгссөний учир шалтгаан тиймийн тул зөөлөн итгэл Богд Зонховын...

...Шашин их эрдэнийг хүндэлбээс **зургаан мутарт** Гомбо Махгал, Чойжил, Лхам тэргүүтэн сахиусыг насад сахиx бөгөөд

Эрх баялаг амар жаргаланг арвижуулах ёс хоёр хослон барилдсан өвөг эцэг хааны ширээнд сууснаас эх дэлхийн зөөлөн торго бүхэл нэг лугаа зургаан барамидын явдлыг анхааран авахуйгаар энэ хойд ашдын эрдэм зөндөө бүтнэ.

Тэр мэт шажин төр авах, орхих өөр ямагтад төгөлдөр буй

Тотийн үглэх мэтийн үг өгүүлэхүүд мэргэн нугууд жигших боловч намрын саран мэт маш цагаан сайхан сэтгэлд гэмгүй үүгээр жишсэн буянаар заяа буян ихтэй хаан, хатан, хөвгүүн сэлт түшмэл¹...

...Машид оршиж зол заяа цог учрал шарманы хүү лугаа адил хувь сайтар болох болтугай.

Тэр мэт хоёр ёс лугаа барилдсан сургаалын зэрэг улаан Сувдан эрх үүнийг Урт наст тэнгэрийн заяагаар хүчний эрх баялаг **Чингис** язгуурт халх түшээт Дорж хан бээр Цаст Төвөдийн оронд чухаг дээд гурав дор багшид бариад, тахил дор залрахын цагт туурвил нэгийг айлдахыг хүссэнд Сахоржийн язгуурын гурван сав аймагтан Агваанлуvsсанжамцжигмэдгочоотүвдэн идэрийн аймгийн их орд Бодалад найруулсан үсгийг омог машид өлзийт Пунцагванбу бичвэй.

Бар тэр мэндэлсний буяны чуулган нугуудаар эх болсон гаслант амьтныг хоцроолгүй Ачит багш лугаа хагацалгүй даган бариад

Ханьцашгүй мөрийн зэргийн эцэст хүрэх болтугай хэмээхийг Дамбийминжан бээр бичсэн болой[19]. Сүүлийн 8 мөрийг нэмж гүйцээв

¹ **Тайлбар:** Уг эхээс 18 мөр дутуу тул “Ёс хоёрын суртгаал сувдан эрх оршуулсан болой” хэмээх гар бичмэлээс нөхөв.